- Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно.
- Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 7.2. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.3. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.4. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

- 8. Баглаа боодол**
- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн СІР /СІП/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ГТН-д тусгайлан заасан бол гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар гаргасан банкны баталгаа, засгийн газрын бонд эсхүл засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаас хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр инкотермсийн нөхцлийн дагуу даатгуулна.

- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан хийнэ.
- 15. Үнэ**
- 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 16. Хуваарийг сунгах**
- 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- (а) захиалагч 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
  - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
  - (в) 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;

- (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэх, арилгахын тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
- 17. Алданги оногдуулах**
- 17.1. Энэхүү гэрээний 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч гэрээг 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
- 18. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй:
- (а) Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
  - (б) Нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
  - (в) Нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;
  - (г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
- 18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- 19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах**
- 19.1. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.

<b>20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах</b>	20.1.	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
	20.2.	Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ:
	(a)	үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
	(б)	үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
<b>21. Маргааныг шийдвэрлэх</b>	21.1.	Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
	21.2.	Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
<b>22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал</b>	22.1.	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
	22.2.	Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
<b>23. Гэрээний үүргийг шилжүүлэх</b>	23.1.	Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
<b>24. Гэрээнд ашиглах хэл</b>	24.1.	Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
	24.2.	24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
<b>25. Татвар болон хураамж</b>	25.1.	Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна болон Монгол Улсын нутаг дэвсгэрт оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
<b>26. Гарчиг</b>	26.1.	Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
<b>27. Үүргийн гүйцэтгэл</b>	27.1.	Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.



---

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

### ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |                                                               |         |                                                                                                                                                                                                                                     |
|---------------------------------------------------------------|---------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Тодорхойлолт<br>(ГЕН - 1)                                  | 1.1.(д) | Захиалагч нь ДЦС-3 ТӨХК                                                                                                                                                                                                             |
|                                                               | 1.1 (ж) | Ажлын талбай нь ДЦС-3 ТӨХК-ийн хашаа, агуулах                                                                                                                                                                                       |
| 2. Шалгалт болон туршилт<br>(ГЕН - 7)                         | 7.0     | Барааг ДЦС-3 ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн холбогдох цахилгаан цехийн ИТА нартай хамтран шалгаж техникийн тодорхойлолтыг үндэслэн хүлээн авч акт үйлдэнэ.                                                           |
| 3. Баглаа боодол<br>(ГЕН - 8)                                 | 8.0     | Барааг төмөр замаар болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн эцсийн цэгт хүргэнэ. Тээвэрлэх, хадгалах үедээ ус бороо, галын аюулаас бүрэн хамгаалагдсан зориулалтын саванд хийж барааны чанарыг алдагдуулахгүй байна. |
| 4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт<br>(ГЕН - 9) | 9.0     | Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:                                                                                                                                                      |
|                                                               | 9.3     | “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (Жишээлбэл СИП):                                                                                                                                                                         |

Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад утсан холбоогоор мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана. Нийлүүлэгч дараах баримт бичгийг захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ:

- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон **[тоо]** ширхэг хуулбар хувийг бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн **[тоо]** ширхэг хуулбар хувийн хамт;
- 3) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;
- 4) даатгалын гэрчилгээ;
- 5) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 6) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;
- 7) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- 9.4 Монгол Улсын дотроос санал болгосон бараа (ИКСБ):
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- |                                                       |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-------------------------------------------------------|------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)</b>            | 11.1 | Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>6. Чанарын баталгаа, баталгаат засвар (ГЕН-13)</b> |      | <p>13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.</p> <p>13.2. Баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна.</p> <p>13.3. Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.</p> <p>13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.</p> <p>13.5. Бараа материалын чанарын баталгаа нь 12 сар байх ба гэмтэл согог гарсан тухай бүр бичгээр мэдэгдэл ирвэл гүйцэтгэгч уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана</p> <p>13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй.</p> |
| <b>7. Даатгал (ГЕН - 12)</b>                          | 12.0 | Даатгалын тусгай шаардлага<br>Даатгалын зардлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>8. Төлбөр (ГЕН - 14)</b>                           |      | Гэрээний ерөнхий нөхцөлийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|                                                       | 14.4 | Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

Барааг бүрэн нийлүүлж дууссаны дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол, нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 30 хоногийн дотор төлбөрийг барагдуулна.

9. Үнэ (ГЕН - 15)	15.1	Гэрээний үнэ гэрээг хэрэгжиж дуустал тогтмол байна.
10. Алданги оногдуулах (ГЕН - 17)	17.1	Алданги оногдуулах хувь: <b>Гэрээний хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээгээр нийлүүлээгүй барааны үнийн дүнгийн 0.3%</b> Алдангийн нийт дүн: <b>Гэрээний нийлүүлээгүй барааны үнийн дүнгийн 30%-иас хэтрэхгүй байна.</b>
11. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлүүлнэ.

---

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ  
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ  
..... /Ч.ЧИНБАТ/

БАТЛАВ  
“.....” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
..... /...../

### ..... ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2019 оны . . . дугаар  
сарын.....ны өдөр

№.....

Улаанбаатар хот

#### Ерөнхий зүйл

Нэг талаас “Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж ....., нөгөө талаас “.....” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/-ийг төлөөлж ..... нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, “Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” ТӨХК-ийн ..... тоот шийдвэр, ..... Зөвлөмж, 2019 оны бизнес төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан энэхүү гэрээг байгуулав.

#### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь ...../цаашид “бараа” гэх/-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу DDP-Улаанбаатар “ДЦС-3” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр нийлүүлнэ.

#### Хоёр. Нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурснаас хойш ..... хоногийн дотор нийлүүлнэ.

#### Гурав. Үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ ..... /үсгээр/ төгрөг бөгөөд үнийн дүнд гааль, онцгой татвар, УБ “ДЦС-3” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2 Гэрээт барааг бүрэн нийлүүлсний дараа төлбөрийг ажлын 30 хоногт багтаан бүрэн төлнө.
- 3.3 Захиалагч нь гэрээний үнийн гүйцэтгэлийн баримт бичгийг үндэслэн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу Нийлүүлэгчийн дансанд төлнө.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгчийн буруугаас бараа нийлүүлэх гэрээнд заасан хугацааг хожимдуулснаас тоноглолын засварын хугацааг сунгах, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулах, хязгаарлахад хүрсэн бол үүнээс үүдэн гарсан хохирлыг Нийлүүлэгч нь Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 4.2 Нийлүүлэгч нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид хоног тутам төлөх ба гэхдээ нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Захиалагч нь Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 4.3 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараах төлбөрийн хугацааг хожимдуулбал төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Нийлүүлэгч нь Захиалагчид бичгээр мэдэгдэнэ.
- 4.4 Нийлүүлэгч нь гэрээг хэсэгчлэн болон бүрэн биеллээгүй тохиолдолд энэхүү гэрээний 4.1 ба 4.2-т заасан хариуцлагаас Нийлүүлэгчийг чөлөөлөхгүй.

**Тав. Бараа, бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодол**

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол Улсын стандарт, техникийн нөхцөл шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлэх бараа нь 2018 оноос хойш үйлдвэрлэсэн, хадгалалтын үед хийгдэх үйлчилгээ хийгдсэн байх, баталгаат хугацаа ашиглаж эхэлснээс хойш ..... байна.
- 5.3 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс бүрэн хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.4 Барааг Захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд мөн чанараа алдахгүй байх ёстой.
- 5.5 Нийлүүлсэн барааны чанарт ямар нэг дутагдал илэрвэл түүнийг засах, сольж өгөхийг Захиалагч шаардах ба Нийлүүлэгч уул шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.6 Барааны баглаа, боодол дараах байдлаар хаяглагдсан байна.
  - Гэрээний дугаар
  - Барааны нэр
  - Хүлээн авагчийн хаяг
  - Ачаа илгээгч
- 5.7 Барааг дараах бичиг баримт дагалдана.
  - Савлалтын хуудас 3 хувь
  - Чанарын гэрчилгээ 3 хувь
  - Барааны гарал үүслийн гэрчилгээ 3 хувь

#### **Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс**

- 6.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн буюу бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль ч хариуцлага хүлээхгүй.
- 6.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөлдөнө.

#### **Долоо. Гэрээг цуцлах журам**

- 7.1 Нийлүүлэгч нь бараа нийлүүлэх хугацааг энэхүү гэрээнд зааснаас 14 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээ цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч нь гэрээг дангаар цуцлана.
- 7.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

#### **Найм. Бусад нөхцөл**

- 8.1 Талууд аль нэг нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 8.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 8.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж Захиалагч 2 хувийг, Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 8.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 8.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.
- 8.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн аливаа оруулга, засвар, нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 8.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.

Энэхүү гэрээ нь үндсэн 3 хуудас, хавсралт 2, хуудас нийт 5 хуудаснаас бүрдэнэ.

**Ес. Талуудын хаяг:**

**Захиалагчийн хаяг:**

Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
“ДЦС-3” ТӨХК-ийн байр  
Утас: 341990, 344111  
Регистр: 2546191  
Банк:  
Төгрөгийн данс:

**Нийлүүлэгчийн хаяг:**

.....  
.....  
Утас: .....  
Регистр:.....  
Банк: .....  
Төгрөгийн данс: .....

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“ДЦС-3” ТӨХК-ИЙН  
.....  
..... /...../

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“..... ” ХХК-ИЙН  
.....  
..... /...../

**ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ  
(БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)**

***ДЦС-3 ТӨХК***

ДЦС-3 ТӨХК нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу \*Тендер шалгаруулалтын нэр\* нийлүүлэх (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

**[Банкны нэр]** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор,төгрөг]** **[дүн үсгээр,төгрөг]** –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор,төгрөг]** **[дүн үсгээр,төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг \_\_\_\_\_

Албан тушаал, нэр \_\_\_\_\_

Банкны тамга

Огноо \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 05 сарын 09 өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Генераторуудын чадлын датчик нийлбэр чадлын сумматорыг шинэчлэхэд шаардлагатай сэлбэг материал.**

### Тендер шалгаруулалтын дугаар: М-33/2019

ДЦС-3 ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **М-33/2019** дугаар : **Генераторуудын чадлын датчик нийлбэр чадлын сумматорыг шинэчлэхэд шаардлагатай сэлбэг материал** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцох хүсэлтэй байгууллагууд тендерийн баримт бичгээ илгээхийн өмнө 50000 төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ сүүлийн 2 жилийн жил тутамд :**70,0 сая** төгрөгөөс дээш.

- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

**24,0 сая төгрөгөөс дээш**

- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил.

- Тендерийн баталгаанд **1 500 000** төгрөг гаргаж ирүүлнэ.

Тендерийг **2019** оны **06** -р сарын **-10** ны өдрийн **11.00** цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг мөн өдрийн **11.30** цагт нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцох шаардлагагүй.

Сонирхсон этгээд мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,  
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар  
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.  
Веб хуудас: [www.tes3.energy.mn](http://www.tes3.energy.mn)



